

**"ФРОНТИЕР ЛЭНД ГРУПП" ХК-ИЙН
2017 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН /II-Р УЛИРЛЫН/ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН**

1. Үнэт цаас гаргагчийн нэр, оршин суугаа хаяг:

Фронттиер Лэнд Групп Нээлттэй Хувьцаат Компани

Хаяг: Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Сөүлийн гудамж 6А, Сити Плаза, 201 тоот

Улаанбаатар 46656, Монгол Улс

Утас: 976-70139949

Имэйл: info@flg.mn

Вэб хуудас: www.flg.mn

2. Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн мэдээлэл:

Улсын бүртгэлийн дугаар: 9010001043

Регистрын дугаар: 5106583

Үнэт цаасны симбол: MDR

Үйл ажиллагааны чиглэл: Гадаад худалдаа, үл хөдлөх хөрөнгийн хөрөнгө оруулалт, түрээс

3. Үнэт цаас гаргагчийн зорилго, үйл ажиллагааны стратеги, түүний хэрэгжилтийн талаарх мэдээлэл:

Эрхэм зорилго:

Харилцагч, үйлчлүүлэгчдийн эрэлт хэрэгцээнд нийцсэн, зах зээлд өрсөлдөх чадвартай бүтээгдэхүүн, үйлчилгээг санал болгон, ашигтай ажиллаж хувьцаа эзэмшигчдийн ашиг сонирхлыг хангах

Зорилт:

- Үйл ажиллагаагаа олон нийтэд таниулж, олон улсын стандартын үйлчилгээг санал болгосноор харилцагч, үйлчлүүлэгчдийн хүрээгээ тэлэх.
- Дотоодын болон гадаадын компаниудтай холбоо тогтоон ажилласнаар үйлчлүүлэгчдийн хүрээгээ тэлж цаашид хамтран ажиллах

4. Үнэт цаас гаргагчийн түүх, тухайн зах зээлд эзэлж буй байр суурь, судалгаа:

“Фронтинер Лэнд Групп” ХК нь анх “Туул Сонгино Усны Нөөц” нэртэйгээр Техникийн Усны Байгууламж, Ундны Усны Байгууламж, Усан Цэнэгт Цахилгаан Станц гэсэн гурван төслийг хэрэгжүүлэхээр 2006 оны 12-р сарын 29-ны өдөр үүсгэн байгуулагдсан.

2007 онд тус компани нь Монголын Хөрөнгийн Биржийн анхдагч зах зээлд хувьцаагаа гаргасан (IPO). Нийт хувьцаанаас 13.2 сая хувьцааг компани арилжаалсан ба 13 200 061 250 төгрөгийг татан төвлөрүүлсэн.

IPO хийсний дараа 2007 оны 12 дугаар сараас эхлэн компани ажилчдынхаа тоо, судлагааны ажлуудаа нэмэгдүүлж, улмаар капитал зардлууд гаргаж эхэлсэн. Тэдгээр томоохон зардлуудаас дурьдвал:

- Улаанбаатарын Сонгино Хайрхан дүүрэгт 17 га ашиглалтын талбайг 1 497 500 000 төгрөгөөр худалдан авсан
- Ундны Ус Цэвэршүүлэх Байгууламжийн зураг төслийн ажлыг гүйцэтгүүлэхээр Хятадын компанитай 505 мянган ам.долларын гэрээ байгуулсан
- тоног төхөөрөмж худалдан авахад 350 сая төгрөг
- төслийн талбайн ажлуудыг гүйцэтгэхэд (хайрга, цахилгааны шугам г.мэт) 358 сая төгрөг
- судалгааны ажилд 300 сая төгрөг тус тус зарцуулсан байна.
- 2009 оны 2 дугаар сарыг хүртэл нийт 4,588,876,575 төгрөгийг Компанийн танилцуулганд тусгагдсан төслүүдийг хэрэгжүүлэхэд зарцуулсан байдаг.

2009 оны эхний хагаст шинэ удирдлага компанийн стратегийн боломжуудыг боловсруулах ажлыг гүйцэтгэсэн ба эхэндээ компанийн танилцуулганд тусгагдсан төслүүдийг олон улсын санхүүгийн байгууллагууд, засгийн газар болон стратегийн хөрөнгө оруулагчдын дэмжлэгтэйгээр хэрэгжүүлэхийн төлөө шинээр сонгогдсон гүйцэтгэх удирдлага идэвхитэй хөөцөлдөн ажилласан. Гэсэн хэдий ч дараах учир шалтгаануудын улмаас эдгээр төслүүдийг хэрэгжүүлэх нь ихээхэн бэрхшээлтэй болох нь тодорхой болсон:

- Усны тариф бага байдаг учир хувьцаа эзэмшигчдэд үр өгөөж өгөх найдвар багатай
- Баталгаатай худалдан авагчид байхгүй,
- Төслийг хэрэгжүүлэхэд хангалттай хөрөнгө байхгүй
- Төслийг хэрэгжүүлэхэд шаардлагатай тусгай зөвшөөрөл, бусад бичиг баримтууд компанийн нэр дээр байдаггүй

Төслийг хэрэгжүүлэх боломжгүй гол шалтгаан нь Компани төслийг хэрэгжүүлэхэд шаардлагатай тусгай зөвшөөрөл, патент, засгийн газрын агентлагуудтай байгуулсан гэрээ зэрэг биет бус хөрөнгүүдийг эзэмшдэггүй байсан юм. Үүсгэн байгуулагчид биет бус хөрөнгөөр компанид хөрөнгө оруулалт хийхгүй байхаар шийдэж, харин тэдгээрийг ашиглан төслүүдээ компаниас хараат бусаар хэрэгжүүлэхээр шийдсэн. Мөн Үүсгэн байгуулагчид компанид хөрөнгө оруулалт хийх үүргээсээ чөлөөлөгдөхийг хүссэн. Тиймээс Компани Үүсгэн байгуулагчидтай гэрээ байгуулсан ба уг гэрээ ёсоор үүсгэн

байгуулагчид үүргээсээ чөлөөлөгдөж энэ дагуу мөн тэдний компанид хувьцаа эзэмших эрх цуцлагдах ёстой байсан юм.

2009 оны 12 дугаар сарын 30-ны өдөр хуралдсан Хувьцаа Эзэмшигчдийн Ээлжит Бус Хуралд оролцсон хувьцаа эзэмшигчид олонхи төслүүдийн хэрэгжилтийг зогсоох, компани үүсгэн байгуулагчдын байгуулсан гэрээг цуцлахыг дэмжсэн.

Үүсгэн байгуулагчид компанийг удирдаж байх үед нийт 4 588 876 575 төгрөгийг Төслүүдийн судалгаа, шинжилгээний ажил гүйцэтгэх, газар, тоног төхөөрөмж худалдан авах, Техникийн Усны Байгууламжийн зураг төслийн ажил хийлгэх болон бас бус Төсөлтэй холбоотой ажлуудад зарцуулсан байдаг. Гэрээ ёсоор эдгээр хөрөнгийг компанийн санхүүгийн тайланд тусгасан бөгөөд, үүсгэн байгуулагчид төсөлдөө хөрөнгө оруулагч олж, компанид 4 588 876 575 төгрөгөө нөхөн төлөхөөс наана хөрөнгийг үүсгэн байгуулагчдад шилжүүлэхгүй байхаар шийдвэрлэсэн.

2010 оны 4 дүгээр сарын 25-ны өдөр хуралдсан Хувьцаа Эзэмшигчдийн Ээлжит Хурлаар үнэт цаасны шинэчилсэн танилцуулгыг эхний байдлаар баталсан ба эцсийн байдлаар батлах эрхийг ТУЗ-д олгосон байдаг. Тус хурлаар мөн Компанийн Дүрмийг шинэчлэн баталсан бөгөөд компанийн нэрийг “Монголиа Девелопмент Ресорсес” ХК болгон өөрчилсөн.

Компанийн шинэчилсэн дүрэм, үнэт цаасны танилцуулгыг Санхүүгийн Зохицуулах Хороо баталсны дагуу Компанийн үнэт цаасны арилжаа 2010 оны 7 дугаар сарын 14-ний өдрөөс сэргээгдэж, МХБ дээр компанийн хувьцаа “MDR” гэсэн шинэ үсгэн кодоор арилжаалагдаж эхлэсэн. (хуучнаар“TSU”). МДР ХК эрхлэх үйл ажиллагаагаа холдинг болгон өөрчилснөөр доорхи салбаруудад хөрөнгө оруулалт хийхээр шийдвэрлэсэн. Үүнд: Үл хөдлөх хөрөнгө, барилга, барилгын материал, үйлдвэрлэл, үйлчилгээ, дэд бүтэц.

2010 оны 10 дугаар сараас эхлэн Компани нь төлөвлөж байсан салбарууддаа хөрөнгө оруулалт хийж эхэлсэн бөгөөд өнөөдөр Эрдэнэговь ланд ХХК, Баянмонгол резиденс ХХК, Реженси ретайл ХХК болон Смарт ланд дайрект гэсэн 4 охин компанитайгаар үйл ажиллагаа явуулж орон сууц, оффис, худалдаа үйлчилгээний үл хөдлөх хөрөнгүүдийг эзэмшиж байна.

2015 оны 4 дүгээр сарын 30-ны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар компанийн үйл ажиллагааг шинэ тулгар зах зээлүүд рүү нэвтрүүлэх зорилгоор компанийн оноосон нэрийг “ФРОНТИЕР ЛЭНД ГРУПП” ХК болгож өөрчлөх шийдвэр гарсан бөгөөд компанийн нэрийг 2015 оны 8 дугаар сарын 17-нд шинэчлэн, гэрчилгээгээ авсан.

Компаний үйл ажиллагааны ерөнхий чиглэл, бизнесийн үндсэн үйл ажиллагаа болон зорилго нь үл хөдлөх хөрөнгө, Улаанбаатар хот болон уул уурхайн эрэлт бүхий хот суурингуудад газар эзэмших замаар орон сууц болон арилжааны зориулалттай үл хөдлөх хөрөнгийг хөгжүүлэх төслүүдийг хэрэгжүүлэх болон гадаад дотоодын хөрөнгө оруулагчдад Монгол улсын эдийн засгийн төрөл бүрийн салбарт хөрөнгө оруулалт хийх

өргөн боломжийг нээж өгөх явдал юм. Зорилгынхоо хүрээнд компани нь оффис, худалдаа үйлчилгээ, орон сууцны барилгуудыг эзэмшиж, түрээслэх үйл ажиллагааг голчлон явуулж байна.

Компаний үйл ажиллагааны ерөнхий чиг, бизнесийн үндсэн үйл ажиллагаа болон зорилго нь цаашид үл хөдлөх хөрөнгө, дэд бүтцийн салбаруудад хөрөнгө оруулалт хийх, Улаанбаатар хот болон уул уурхайн эрэлт бүхий хот суурингуудад газар эзэмших замаар орон сууц болон арилжааны зориулалттай үл хөдлөх хөрөнгийг хөгжүүлэх төслүүдийг хэрэгжүүлэх, гадаадын орнуудын үл хөдлөх хөрөнгийн салбарыг судалж хөрөнгө оруулалт хийх гэх мэт төрөл бүрийн үйл ажиллагааг эрхлэх болно.

Компани нь Монгол улсад явуулж буй үл хөдлөх хөрөнгийн салбарын үйл ажиллагаагаа өргөжүүлэн тэлэхийн зэрэгцээ, шинэ тулгар хөгжиж буй улсуудын үл хөдлөх хөрөнгийн салбаруудад нэвтрэхээр төлөвлөж байна. Компани нь 10 хүртэлх тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтыг шинэ тулгар хөгжиж буй зах зээлтэй улсуудын үл хөдлөх хөрөнгийн зах зээлд хийхээр төлөвлөж байна. Компани нь нарийвчилсан магадлан шинжилгээ хийсний үндсэн дээр эдгээр зорилтот хөрөнгө оруулалтуудыг хийх эсэхээ шийднэ. Эдгээр хөрөнгө оруулалтуудыг хийх гол зорилго нь ашиг олох явдал юм. Эдгээр боломжит хөрөнгө оруулалтуудыг санхүүжүүлэх гол эх үүсвэр нь дотоодын банкуудад байршуулсан мөнгөн хөрөнгө болон түүнтэй адилтгах хөрөнгө, дотоодын банкуудаас авах зээл болон хувьцаа нэмж гаргаснаар татан төвлөрүүлэх хувьцаат капиталын эх үүсвэр байх юм.

5. Үнэт цаас гаргагчийн бараа бүтээгдэхүүн, үйлчилгээний зах зээлд гаргасан томоохон өөрчлөлт, үүнтэй холбоотой үүсч болох эрсдлийн тухай мэдээлэл:

2017 оны хагас жилийн байдлаар гадаадын шууд хөрөнгө оруулалт өмнөх онуудаас эрчимтэйгээр буурч, экспортын гол нэрийн бүтээгдэхүүнүүдийн олон улсын үнэ буурч байгаа нь улсын эдийн засагт хүндээр тусч байна. Эдийн засгийн энэхүү хүндрэлтэй байдал бүхий л салбарт, үүний дотор үл хөдлөх хөрөнгийн бүтээн байгуулалт, оффис, үйлчилгээ, орон сууцны түрээсийн бизнесийн салбарт сөргөөр нөлөөлсөөр байна. Түрээсийн бизнесийн хувьд түрээслэгчид хямд түрээсийн талбай хайх, түрээслэх талбайг жижигрүүлэн нүүх, түрээсийн үнийг буулгах тулгалт хийх зэрэг эрсдлүүд гарч болох юм. Эдийн засгийн ийм хүндрэлтэй нөхцөлтэй байсан ч тус компани нь Реженси Резиндэнс дэх 2000 гаруй м2 талбайг бүхэлд нь түрээслэгчтэй байлгаж чадлаа.

6. Үнэт цаас гаргагчийн удирдлага, эрх бүхий албан тушаалтнуудын танилцуулга /цагаан толгойн дарааллаар/:

1	Батбилэг С.	ТУЗ-ийн хараат бус гишүүн, ТУЗ-ийн Цалин урамшууллын хорооны гишүүн
2	Батсайхан Д.	ТУЗ-ийн гишүүн, Компанийн ерөнхий нягтлан бодогч
3	Камолиддин Талипов	ТУЗ-ийн гишүүн, ТУЗ-ийн Нэр дэвшүүлэх хорооны дарга
4	Мэндбаяр Ц.	ТУЗ-ийн хараат бус гишүүн, ТУЗ-ийн Аудит, Нэр Дэвшүүлэх хорооны гишүүн
5	Оюунболд Г.	ТУЗ-ийн гишүүн
6	Өлзийбаяр Б.	ТУЗ-ийн гишүүн, ТУЗ-ийн Аудитын Хорооны гишүүн
7	Төвшин М.	ТУЗ-ийн гишүүн, Компанийн Гүйцэтгэх Захирал
8	Үнэнбат Д.	ТУЗ-ийн гишүүн, Аудитын Хорооны дарга, Нэр дэвшүүлэх, Цалин урамшууллын хорооны гишүүн
9	Эльер Хасанов	ТУЗ-ийн Дарга, Цалин урамшууллын хорооны дарга
10	Буянтогтох М.	ТУЗ-ийн Нарийн Бичгийн дарга

7. Үнэт цаас гаргагчийн нийт гаргасан хувьцааны 5 болон түүнээс дээш хувийг эзэмшигчдийн мэдээлэл:

/2017 оны 2 дугаар сарын 07-ны байдлаар/

Хувьцаа эзэмшигч	Хувьцааны тоо ширхэг	Эзлэх хувь
Mongolia Capital	3,823,744	27.81%
ECMGL	2,317,799	16.86%
Discovery Fund	2,030,832	14.77%
Opportunity Fund	1,600,000	11.64%
Eastinvestor	1,000,000	7.27%
Firebird global master fund	971,569	7.07%
FIREBIRD MF Holdings	850,884	6.19%

8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлт:

Компаний 2017 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлан, орлого үр дүнгийн тайланг 2017.01.01-2017.06.30 - ний байдлаар өссөн дүнгээр Монгол улсад мөрдөгдөж байгаа хууль тогтоомж заавар журам, нягтлан бодох бүртгэлийн болон санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бэлтгэж тайлан хүлээн авах эрх бүхий газруудад хуулийн хугацаанд хүргүүлдэг.

Мөн компаний дотоод гадаад хөрөнгө оруулагчид, мэдээлэл хүлээн авагчид хүртээмжтэй болгох үүднээс компаний веб сайтанд байршуулан мэдээлэл шуурхай авах боломжоор ханган ажиллаж байна.

1. Нийт хөрөнгө

Нийт хөрөнгө буюу тэнцэл нь Жилийн эхэнд байсан нийт хөрөнгө 16644.3 сая төгрөгөөс 2017 оны хагас жилийн байдлаар 16537,7 сая төгрөг болсон байна. Үүнд 2017 оны хагас жилийн байдлаар эргэлтийн хөрөнгө 54.68% хувийг, эргэлтийн бус хөрөнгө 45,32% хувийг эзэлж байгаа нь санхүүгийн хувьд тогтвортой үйл ажиллагаа явагдсан. Эргэлтийн хөрөнгө болон үндсэн хөрөнгө, хөрөнгө оруулалтын зориулалтай хөрөнгөө, удирдах зөвлөлийн шийдвэрийн дагуу борлуулж хөрөнгө оруулалтанд оруулж хөрөнгө худалдаж авах, бусад үйл ажиллагааг санхүүжүүлэн төлбөрийн чадварын хувьд бүрэн боломжтой юм.

Өглөгүүдийн хувьд ихэвчлэн түрээсийн барьцаа болон хэвийн хэмжээний төлбөр хамаарч байна.

2. Орлогын тайлан

Үйл ажиллагааны орлогын тухайд 2017 оны хагас жилийн эцсийн байдлаар 328,4 сая төгрөг байна.

Үйл ажиллагааны зардлын тухайд 2017 онд 364,0 сая төгрөгийн зардал гарсан. 2017 оны хагас жилийн зардалд тодорхой хэмжээгээр нөлөөлөл үзүүлсэн томоохон хэмжээний зардлууд нь оффис зориулалттай үл хөдлөх хөрөнгийг элэгдүүлж эхэлсэнтэй холбоотойгоор хэвийн хэмжээний элэгдлийн зардал 19.6 хувь /71.5 сая төгрөг/, үйлчилгээний зардал, бусад зардалд газрын болон үл хөдлөх хөрөнгийн татварыг тооцож төлсөн, эргэлтийн хөрөнгийг санхүүжүүлэх зээлийн хүүгийн зардал 62,08 Хувь /226,0 сая төгрөг/-р зохих хэмжээгээр нэмэгдсэн нь манай байгууллагын хувьд үйл ажиллагаагаа хэвийн явуулах, цаашид олох орлогоо нэмэгдүүлэх, байр худалдах зорилгоор өөрийн эзэмшлийн хөрөнгүүдийг сайжруулахад, засвар үйлчилгээ хийлгэх, зах зээл дээр хөрөнгийн түрээс болон үнийн уналттай холбоотойгоор тодорхой хэмжээгээр орлого болон зардлаа хэвийн хэмжээнд байлгах талаар тодорхой арга хэмжээ авч ажилласан.

3. Татварын тайлан

Манай байгууллагын хувьд Монгол улсын татварын хууь тогтоомж, заавар журмын дагуу хуулийн хугацаанд татварын тайлан гаргаж цахимаар илгээн татвараа тухай бүрд нь төлж байгаа болно.

9. Компанийн тухай хуульд заасан их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцлийн талаарх мэдээлэл:

Тайлант хугацаанд их хэмжээний болон, сонирхлын зөрчилтэй хэлцэл хийгдээгүй.

10. Үнэт цаас гаргагчийн гүйцэтгэх удирдлагын хийж гүйцэтгэсэн ажлын талаарх мэдээлэл:

2017 оны эхний хагас жилийн хугацаанд улс орны хэмжээнд эдийн засгийн хүндрэл үргэлжилсэн хүндхэн үе байсан хэдий ч, Фронтьер Лэнд Групп ХК-ийн хувьд түрээсийн бизнесээ амжилттай явуулж, Реженси Резиденс дэх бүх оффис, үйлчилгээний талбайгаа, БаянМонгол хороолол дахь орон сууцнуудынхаа дийлэнхийг түрээслэгчтэй байлгаж чадлаа.

Тайлант хугацаанд компанийн удирдлага оффис, үйлчилгээ, орон сууцны түрээслэгчидтэй байнгын нягт харилцаатай ажиллаж, гарсан гомдол санал хүсэлтийг цаг тухай бүрт нь шийдвэрлэсээр ирлээ.

Реженси Резиденс цогцолборын зүүн жигүүрийн хоёр, гуравдугуур давхрын оффис, үйлчилгээний талбайн хөрөнгө оруулалтын санхүүжилтыг хийх зорилгоор ТУЗ-ийн тогтоолын дагуу Худалдаа Хөгжлийн Банкнаас 500 сая төгрөгийг 2016 оны 4-р сард зээлээр авсан бөгөөд, сар бүр үндсэн зээл, зээлийн хүүг цаг хугацаанд нь төлсөн.

Манай түрээслэгч болох Бүгд Найрамдахчуудын Хүрээлэнгээс оффисийн талбайг томсгож өгөх, боломжгүй бол өөр оффис рүү нүүх болсон тухайгаа шаардлага тавьсны дагуу хөрш түрээслэгч QMC компанитай харилцан зөвшилцсөнөөр тэдний оффисийн талбайгаас Бүгд Найрамдахчуудын хүрээлэнд тасалж өгч томсгож асуудлыг шийдвэрлэсэн.

Манай түрээслэгч Глобал сангийн зүүн тийш харсан нар тусдаггүй цонхнуудыг давхарлан шиллэж, дулаан алдагдалтыг багасгасан.

2-р давхрын эрэгтэй, эмэгтэй жорлонгуудыг хуруу мэдрэгчтэй цоожоор тоногосноор, зөвхөн манай түрээслэгчид орох боломжтой болж, түрээслэгчдийн тав тухыг хангасан.

Түрээслэгчдийн хүсэлтийн дагуу аяга таваг угаах угаалтуурын өрөөг корридорт суурилуулж өгснөөр түрээслэгчдийн тав тухыг ханган, эрүүл ахуй, ариун цэврийн шаардлагыг хангаж өгсөн.

Манай түрээслэгч Франц рестораны хүсэлтийн дагуу уг ресторанд агааржуулалтын систем суурилуулж өгснөөр, хиншүү багасч, үйлчлүүлэгчид тав тухтай үйлчлүүлэх боломжтой болсон.

Манай компанийн зүгээс Реженси Резиденс цогцолборын СӨХ-д удаа дараа хүсэлт гаргасны хүчинд, уг цогцолборын урд талын гадна хаалганд давхар хаалга хийлгүүлж, дулаан алдагдалтыг багасган, нэгдүгээр давхрын түрээслэгчдийн тав тухыг хангахад дөхөмтэй болсон.

Манай түрээслэгч Донна Скарпиа гутлын дэлгүүрийн тавиуруудын ард далдлагдсан паарнуудад шугам хоолойн дахин төлөвлөлт хийснээр үйлчилгээний талбайд ил гаргаж өгч, дулаан алдагдалтыг багасгасан.

Реженси Резиденс цогцолбор дахь нэгдүгээр давхрын түрээслэгч болох Хаан банкны салбарын шилэн хаалга суулт өгч, онгойж хаагдахад хүндрэлтэй болж, улмаар нурж унах ч аюултай байсныг яаралтай арга хэмжээ авч, төмөр раамтай шинэ шилэн хаалтаар сольсноор болзошгүй аюул, ослоос сэргийлсэн.

11. Үнэт цаас гаргагчийн хувьцаа эзэмшигчдийн хурал, түүний шийдвэр:

Хувьцаа Эзэмшигчдийн Ээлжит Хурлыг 2017 оны 4 дүгээр сарын 28-ны өдөр амжилттай зохион байгуулсан. Хурлын ирц 91,64 хувьтай байлаа.

Хурлаар дараах асуудлуудыг баталсан болно.

	Хэлэлцсэн асуудлууд	Зөвшөөрсөн саналын тоо	Хувь
1.	Компанийн 2016 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг батлах	12,594,828	100%
2.	2017 оны Компанийн бизнес төлөвлөгөөг батлах	12,594,828	100%
3.	Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг өөрчлөх асуудлыг хэлэлцэж, батлах	12,594,828	100%
4.	Фронтьер Лэнд Групп ХК-ийн нэмэлт хувьцаа гаргах асуудлыг хэлэлцэж, батлах	12,594,828	100%
5.	Компанийн хувьцааг тэргүүн ээлжинд худалдаж авах болон хувьцааг эргүүлэн компанид худалдах шаардах эрх хэрэгжүүлэх тухай хэлэлцэх	12,594,828	100%
6.	Компанийн Дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулж, шинэчилсэн найруулгыг батлах	12,594,828	100%
7.	Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдийг сонгох	12,594,828	100%
8.	Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2017 оны төсвийг батлах	12,594,828	100%
9.	Ногдол ашиг тараахгүйгээр шийдвэрлэсэн тухай ТУЗ-ийн шийдвэрийг танилцуулах	12,594,828	100%
10.	Компани, үүсгэн байгуулагчдын хооронд байгуулсан Туул Сонгино Усны Нөөц Цогцолбор төслийг хэрэгжүүлэх	10,772,375	85,53%

	гэрээнд оруулсан нэмэлт өөрчлөлтүүдийг батлах		
11.	Бусад	9,772,375	77,59%

12. Үнэт цаас гаргагчийн ТУЗ-ийн аливаа шийдвэр:

Компанийн 2017 оны Хувьцаа Эзэмшигчдийн Хурлаас хоёр жилийн хугацаагаар шинээр сонгогдсон Төлөөлөн Удирдах Зөвлөл нь 2017 оны 5 дугаар сарын 09-нд хуралдаж ТУЗ-ийн хороодыг дараах байдлаар сонгосон:

ТУЗ-ийн Дарга

Эльер Хасанов

ТУЗ-ийн Аудитын Хороо

Д. Үнэнбат /Дарга/

Ц. Мэндбаяр

Б. Өлзийбаяр

ТУЗ-ийн Нэр Дэвшүүлэх Хороо

Камолиддин Талипов /Дарга/

Ц. Мэндбаяр

Д. Үнэнбат

ТУЗ-ийн Цалин Урамшууллын Хороо

Эльер Хасанов /Дарга/

С. Батбилэг

Д. Үнэнбат

ТУЗ-ийн Нарийн бичгийн дарга

Г. Санжаасүрэн

2017 оны ТУЗ-ийн шийдвэрүүд:

2017 оны 1 дүгээр сарын 23-ны өдрийн ТУЗ-ийн хурлаас дараах шийдвэрүүд гарсан:

- 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд аудит хийх аудитын компаниар Сүлд Аудит компанийг сонгов

- ТУЗ-ийн нарийн бичгийн даргаар Г. Санжаасүрэнг томилов.

2017 оны 2 дугаар сарын 17-ны өдрийн ТУЗ-ийн хурлаас дараах шийдвэрүүд гарсан:

- 2016 оны санхүүгийн жилийн аудитлагдсан санхүүгийн тайланг батлав
- Ногдол ашиг хуваарилахгүй шийдвэр гарав.

2017 оны 03 дугаар сарын 13-ны өдрийн ТУЗ-ийн хурлаас гарсан шийдвэрүүд:

1. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдуулах тухай шийдвэр гаргах
- Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2016.04.28-ний өдөр 18:00 цагаас Пума Имperiал зочид буудлын хурлын бага танхимд хуралдуулах, хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийг бүртгэх бүртгэлийн өдрийг 2016.04.05-ны өдрөөр тус тус тогтоох, хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэх асуудлууд болон хурлаас өмнө хувьцаа эзэмшигчдийн танилцах бичиг баримтын жагсаалт, олон нийтэд мэдээлэх зарын загвар, саналын хуудасны агуулга, хурлын дэгийг ТУЗ-ийн хурлын тогтоолын хавсралтуудаар тус тус батлах, хувьцаа эзэмшигчдийн хурлыг зохион байгуулах үйл ажиллагааг Евразиа Капитал Холдинг ХК-аар гүйцэтгүүлэх, хурлыг зохион байгуулах комиссын даргаар Гүйцэтгэх Захирал М.Төвшин, комиссын гишүүнээр ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Г. Санжаасүрэнг, мөн хувьцаа эзэмшигчдийн хурлын даргаар Г. Оюунболдыг, тооллогын комиссын даргаар Т. Булган, гишүүдээр Э. Саранчимэг, Г. Алтаймаа нарыг томилохыг санал хураалтанд оролцсон есөн гишүүний 100%-ийн саналаар батлав.

2. Бусад асуудлаар шийдвэр гаргах. Үүнд:

Нэг. Компанийн 2016 оны үйл ажиллагаа болон санхүүгийн тайлангийн талаарх Гүйцэтгэх Захирлын тайланг Хавсралт 1-ээр баталсугай.

Хоёр. Компанийн 2016 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг тогтоолын Хавсралт 2-оор баталж, хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд танилцуулж, батлуулсугай.

Гурав. Компанийн 2017 оны бизнес төлөвлөгөөг тогтоолын Хавсралт 3-аар баталж, хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд танилцуулж батлуулсугай.

Дөрөв. Компани нэмэлт хувьцаа гаргахтай холбогдуулан компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг өөрчлөх, хувьцааны нэрлэсэн үнийг бууруулах, шийдвэрлэх арга замуудыг хэлэлцэн баталж, хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд танилцуулж батлуулсугай.

Тав. Компанийн үйл ажиллагааг тэлэхэд шаардлагатай нэмэлт хөрөнгө оруулалтыг татах зорилгоор нэмэлт хувьцаа гаргахыг баталж, хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцүүлсүгэй.

Зургаа. Компанийн Дүрмийн шинэчилсэн найруулгын төслийг Хавсралт 4-өөр баталж, хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд батлуулахаар оруулсугай.

Долоо. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2017 оны цалин, урамшуулал, үйл ажиллагааны төсвийг тогтоолын Хавсралт 5-аар тогтоох тухай саналыг хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцүүлэн батлуулсугай.

Найм. Компани, үүсгэн байгуулагчдын хооронд байгуулсан Туул Сонгино Усны Нөөц Цогцолбор төслийг хэрэгжүүлэх гэрээний сунгалтын төслийг тогтоолын Хавсралт 6-аар баталж, хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд батлуулахаар оруулсугай.

Ес. Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зохион байгуулах үйл ажиллагааг Евразиа Капитал Холдинг ХК-аар гүйцэтгүүлэхийг зөвшөөрч, холбогдох гэрээг тогтоолын Хавсралт 7-оор баталсугай.

Арав. Тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг холбогдох албан тушаалтнуудад үүрэг болгосугай

2017 оны 5 дугаар сарын 09-ний өдрийн ТУЗ-ийн хурлын шийдвэр:

- ТУЗ-ийн дарга, хороодын гишүүдийг сонгов.
- ТУЗ-ийн Нэр Дэвшүүлэх хороо, ТУЗ-ийн даргын оруулсан саналыг үндэслэн тус компанийн Гүйцэтгэх Захирал Мэнд овогтой Төвшинг хоёр жилийн хугацаагаар Гүйцэтгэх Захирлаар улируулан сонгохоор эчнээ санал хураалтанд оролцсон нийт есөн гишүүний 100 хувийн саналаар баталж, түүнтэй байгуулах хөлсөөр ажиллах гэрээг хавсралтаар батлав.
- Туул сонгино усны нөөц цогцолбор төслийг хэрэгжүүлэх гэрээний хүрээнд тус компанийн эзэмшлийн төслийн талбай дээрх эд хөрөнгө, тоног төхөөрөмжийг УБ Усан Цэнэгт Цахилгаан Станц ХХК-д түр хугацаагаар ашиглуулах тухай батлав.

2017 оны 6 дугаар сарын 28-ны өдрийн ТУЗ-ийн хурлын шийдвэр:

- Сүхбаатар дүүргийн 1 дүгээр хороонд байрлах Реженс Резиденс цогцолборын 2, 3 дугаар давхрын оффис, үйлчилгээний талбайг захиалан хөрөнгө оруулалт хийх Монголиан Пропертиз ХХК-тай байгуулах “Үйлчилгээний талбай захиалан бариулах гэрээг” батлав.